




**Зураг 1.** Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг




2019 оны 7-р сарын 10-ний байдлаар 1 кг үхрийн цул мах 14817 төгрөг, үхрийн /ястай/ мах 12457 төгрөг, хонины /ястай/ мах дунджаар 10076 төгрөг, адууны /ястай/ мах 9496 төгрөг, ямааны /ястай/ мах 8546 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

**Гурилын үнэ:** 2019 оны 7-р сарын 10-ний байдлаар гурилын үнэ өмнөх сараас дээд зэргийн савласан гурилын үнэ 3.9 хувь, 1-р зэргийн савласан гурилын үнэ 3.6 хувь, 2-р зэргийн савласан гурилын үнэ 1.1 хувиар өсч, дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 1.5 хувиар буурчээ.

Өмнөх 7 хоногоос дээд зэргийн савласан гурилын үнэ 0.8 хувь, 1-р зэргийн савласан гурилын үнэ 0.7 хувиар өсөж, дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 0.1 хувиар буурч, 2-р зэргийн савласан гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

**Будаа, элсэн чихрийн дундаж үнэ:** 2019 оны 7-р сарын 10-ний байдлаар цагаан будаа, элсэн чихрийн үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна (Зураг2).

**Зураг 2.** Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



**Төмс, хүнсний ногооны дундаж үнэ:** 2019 оны 7-р сарын 10-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнэ өмнөх сараас луувангийн үнэ 9.3 хувь, төмсний үнэ 7.6 хувь, хүрэн манжингийн үнэ 5.6 хувиар өсч, байцааны үнэ 12.2 хувиар буурч, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногоос луувангийн үнэ 0.1 хув өсөж, төмсний үнэ 0.1 хувиар буурч, бусад ногооны үнэ өөрчлөлтгүй байна.

**Сүү, өндөг, ургамлын болон цэцгийн тосны дундаж үнэ:** 2019 оны 7-р сарын 03-ний байдлаар өмнөх сараас задгай сүүний үнэ 27.2 хувь, савласан сүүний үнэ 0.2

хувиар буурч элекстер сүүний үнэ өөрчлөлтгүй байна. Өмнөх 7 хоногоос задгай сүүний үнэ 26.5 хувь, савласан сүүний үнэ 0.2 хувиар буурч элекстер сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Цөцгийн тосны үнэ өмнөх сараас 11.5 хувиар буурч, өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Ургамлын тосны үнэ өмнөх сараас 0.5 хувиар өсөж, өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Өндөгний үнэ өмнөх сараас 0.1 хувиар өсөж, өмнөх 7 хоногоос 0.5 хувиар буурсан байна.

**ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар  
2019 оны 7-р сарын 10**